

***ХАМТАРСАН БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
САЛБАР ДУНДЫН БАЙГУУЛЛАГУУДЫН
ОРОЛЦОО, ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ***

***ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА
С.ЭНХБОЛД***

“ХАМТАРСАН БАГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ”

3.4. Хамтарсан багийн гишүүдээр сум хорооны хэсгийн төлөөлөгч, өрх/багийн эмч/эрүүл мэндийн нийгмийн ажилтан, сургуулийн нийгмийн ажилтан, **халамжийн нийгмийн ажилтан** ажиллана.

Дархан сум

Дархан сумын 1-16,
Малчин, Өргөө
“Хамтарсан баг”-ийн
бүрэлдэхүүн
/15 мэргэжилтэн/

Шарын гол
сум

Шарын гол сумын
“Хамтарсан баг”-ийн
бүрэлдэхүүн
/1 мэргэжилтэн/

Орхон сум

Орхон сумын
“Хамтарсан баг”-ийн
бүрэлдэхүүнд
байдаггүй

Хонгор сум

Хонгор сумын
“Хамтарсан баг”-ийн
бүрэлдэхүүнд
байдаггүй

3.1. Сум, дүүргийн Засаг дарга нь сум, хорооны хамтарсан багийн бүрэлдэхүүнийг захирамжаар томилж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллана.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын харьяа сум, багийн Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан **16 мэргэжилтэн** “Хамтарсан баг”-ийн бүрэлдэхүүнд ажиллаж байна.

“ХАМТАРСАН БАГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ”

3.12. Сум, хорооны халамжийн нийгмийн ажилтан дараах үүрэг хүлээнэ.

3.12.1. халамжийн үйлчилгээ үзүүлэх явцад илэрсэн гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн болзошгүй эрсдлийн талаарх мэдээллийг сум, хорооны нийгмийн ажилтан, хамтарсан багийн бусад гишүүдэд мэдээлэх, нөхцөл үнэлгээ хийхэд нийгмийн ажилтан, хэсгийн байцаагчтай хамтран ажиллах;

3.12.2. үйлчилгээнд хамрагдагчийн нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн хууль, тогтоомжид заасан нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаанд хамруулах;

3.12.3. эрсдэлд байгаа хүүхдийг олон нийтэд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамруулах

3.12.4. халамж, хамгааллын үйлчилгээ авч буй хүүхэд, гэр бүлд хяналт тавих, хамтарсан багийн гишүүдтэй санал дүгнэлтээ хуваалцах;

3.12.5. хүчирхийлэлд өртсөн хүүхэд, гэр бүлд чиглэсэн халамжийн үйлчилгээний тухай мэдээ, тайланг хамтарсан багийн гишүүд болон дээд шатны байгууллагад тайлагнах.

3.14. Хамтарсан багийн гишүүн ажлаас гарах, халагдах, өөр албан тушаалд шилжих зэрэг тохиолдолд тухайн албан тушаалд томилогдсон ажилтан, албан тушаалтан нь хамтарсан багийн гишүүний үүргийг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

“ХАМТАРСАН БАГ”-ИЙН БҮРЭЛДЭХҮҮНД АЖИЛЛАСАН БАЙДАЛ

5.6. Сум, хорооны халамжийн нийгмийн ажилтан дараах шуурхай тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

5.6.1. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээний дүгнэлтэд үндэслэн нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаанд хүүхэд, гэр бүлийн гишүүдийг хамруулах, шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах;

/Хүүхдийн хүчирхийлэл/ кейс - 4

/Ахмад настны хүчилхийлэл/ кейс - 6

/Гэр бүлийн хүчирхийлэл/ кейс - 6

/Архидан согтуурах, гэр бүлийн орчинд танхайрах/ кейс - 14

Нийт **30** кейсэд хамтран оролцсон

ХХҮГ-аас хэрэгжүүлж буй ажлын товч мэдээлэл:

Ахмад настны асрамжийн газарт тус онд **4** ахмад настанг хүргүүлсэн.

- ❖ "Ахмад настны үндэсний төв" асрамжийн газар – **3**
- ❖ "Ачлалт хүүхдүүд" асрамжийн газар - **1**

Хүүхдийн асрамжийн газарт тус онд **2** хүүхэд өгсөн.

- ❖ "Нарны хүүхдүүд" – **1**
- ❖ "СОС" хүүхдийн хотхон - **1**

Түр байршуулах, халуун хоол цайгаар үйлчлэх, бичиг баримтжуулах үйлчилгээнд **8** иргэнийг хамруулсан.

- ❖ "Мөнхтийн таг" ТББ-ын түр байршуулах байр – **1** том хүн **3** хүүхэд /гэр нь шатсан/
- ❖ ХХҮГ-ын харьяа брак байр – **2** ахмад настан, **2** том хүн

Архинд донтох өвчтэй, архи ухаараа гэр бүлийнхээ амгалан тайван байдлыг эвддэг, дээрх шалтгаанаар удаа дараа сатуулагдаж байсан **11** иргэнийг архины сайн дурын эмчилгээнд хамруулж байна. /ОХУ-ын Буриад улсын Улан-Үд хотод эмчилгээнд хамруулна/

ХХҮГ-аас зохион хэрэгжүүлж буй ажлын товч мэдээлэл:

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдаж чаддаггүй **39** хүүхдийг төрийн болон хувийн 11 цэцэрлэгт хамруулсан.

Ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй зорилтот бүлгийн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай **135** хүүхдэд /7,8 сая төгрөг/ хичээлийн хэрэгсэл олгох ажлыг зохион байгуулсан.

Зорилтот өрхийн **268** хүүхдийг эрүүл мэндийн урьдчилан үзлэгт хамруулах ажлыг Эрүүл мэндийн газар, Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран зохион байгуулсан.

Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулалт:

Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа иргэний асаргааны мөнгөн тэтгэмж – **46** /32,543.130 төгрөг/

Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон биш мах бодын хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа хүүхдийн авулгүй байдлыг хангах зорилгоор Хүүхэд хамгааллын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамрагдсан байгаа хүүхдийн асаргааны мөнгөн тэтгэмж – **14** /8,936.172 төгрөг/

Эцэг эх нь эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон болон эцэг эх байх эрхээ хязгаарлуулсан хүүхдийн асаргааны мөнгөн тэтгэмж – **1** /687.390 төгрөг/

Гэнэтийн аюул осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар гэр оронгүй, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон өрх, иргэнд олгох мөнгөн тэтгэмж – **20** /44,0 сая төгрөг/

18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд олгох мөнгөн тэтгэмж – **14** /16,8 сая/

Хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй иргэнд олгох мөнгөн тэтгэмж – **16** /19,2 сая/

Дүгнэлт:

- “Хамтарсан багийн ажиллах журам”-д заасны дагуу тухайн шатны Засаг даргын захирамж, журмын заалтын хэрэгжилтийг хангаж сум, багийн “Хамтарсан баг”-ийн бүрэлдэхүүнд орж, журмаар хүлээсэнн үүрэг, зорилтот иргэдэд хүргэх үйлчилгээг хүргэн ажиллаж байна.
- Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд зорилтот өрх, өрхийн гишүүн-иргэн, хүүхэд нийт **508** иргэнийг нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээнд хамруулсан. 2019 оны 09 сарын 30-ны байдлаар
 1. Нийгмийн хамгааллын үйлчилгээ – **397** иргэн /7,8 сая төгрөг/
 2. Нийгмийн халамжийн үйлчилгээ – **111** иргэн /122,2 сая төгрөг/

Харж хандах хүнгүй ганц бие ахмад настан, орон гэргүй тэнэмэл өрх, иргэн, гэнэтийн аюул ослын улмаас гэр оронгүй болсон өрх, иргэний асуудлыг шийдвэрлэх хугацаанд ХХҮГ-ын харьяа хуучин брак байрыг түр байршуулах байр болгон ашиглаж ирсэн боловч эвдрэл ихтэй улмаас ашиглах өрөө байхгүй болсон.